

MEC

MONGOLIA ENERGY CORPORATION

М о Э н К о Х Х К

ХӨШӨӨТ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Компанийн тухай

МоЭнКо ХХК нь Хонконгийн Олон Улсын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Монголия Энержи Корпорэйшн Лимитэд (МЕК) компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2007 онд байгуулагдаж, Хөшөөтийн чулуун нүүрсний ордын тусгай зөвшөөрлийг эзэмшин ашигт малтмалын хайгуул, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Цомхон бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн тус компани өнөөдөр Монголын баруун бүс нутаг, тэр дундаа олон үндэстний өлгий нутаг хэмээн алдаршсан Ховд аймгийн хэмжээнд уул уурхайн томоохон төсөл болон өргөжиж, Монгол Улсын хөгжил дэвшилд бодитой хувь нэмрээ оруулсаар байна.

Компани хариуцлагатай уул уурхайн тэргүүн туршлага, аюулгүй ажиллагааны стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд үйлдвэрлэлийн цар хүрээгээ нэмэгдүүлэн, улмаар олон улсын коксжих нүүрсний зах зээлд бүтээгдэхүүний чанараараа өрсөлдөхүйц бөгөөд салбартаа тэргүүлэх компани болохыг эрхэм зорилгоо болгодог.





Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд уурхайг ашиглахтай холбоотой дэд бүтцийг иж бүрэн шийдвэрлэх, нутгийн ард иргэдийг үндэсний мэргэжилтэй боловсон хүчин болгон ажлын байран дээр нь сурган дадлагажуулах, аж ахуйн нэгж байгууллагуудын бизнесийн туршлагыг нэмэгдүүлэн, орон нутгийн хөгжлийн стратегийг хамтдаа тодорхойлж, төслийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлж байна. Төслийн хөрөнгө оруулалтаар улсдаа хамгийн уртад тооцогдох 311 км нүүрс тээврийн зам, нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, Хөшөөтийн уурхай болон Үенч суманд гаалийн хяналтын талбай зэрэг томоохон бүтээн байгуулалтуудыг хийсэн. Төслийн хэмжээнд 2200 хүн ажлын байраар хангагдан ажиллаж байна. Тэдгээрийн 80 орчим хувийг Ховд аймгийн иргэд бүрдүүлдэг.

Хөшөөт төсөл нь баруун бүсээс нүүрс экспортолж буй анхны төсөл билээ. Төслийн бүтээн байгуулалт, техник технологийг сайжруулах замаар үр өгөөжийг нь улам бүр нэмэгдүүлж, бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмрээ оруулах нь Компанийн тэргүүлэх зорилт юм.

Хөшөөтийн уурхай нь Ховд аймгийн Дарви сумын нутагт Ховд хотоос зүүн урагш 210 км, Зэрэг сумаас баруун урагш 60 км, Цэцэг сумаас зүүн хойш 29 км, Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойд хэсэгт далайн түвшнээс дээш 1900-2250 метр өндөрт оршдог.



2200 хүний ажлын байр



311 км хатуу хучилттай засмал зам



Шилдэг технологи



Нүүрс хуурай аргаар баяжуулах үйлдвэр



Нүүрс химийн лаборатори



Нүүрс угаах үйлдвэр



Үндэсний үйлдвэрлэгчдийн хамтын төсөл



ТОП-100 аж ахуйн нэгжийн нэг



Баян-Өлгий

Увс

Завхан

Ховд

Говь-Алтай

ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



Хөшөөт-Ярант чиглэлийн 311 км хатуу хучилттай зам

МоЭнКо ХХК нь олборлолтын үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар эрхлэх зорилгын үүднээс ашиглалтын үйл ажиллагааг эхлэхээс өмнө Хөшөөт-Ярант боомт чиглэлийн 311 км хатуу хучилттай зам, 17 гүүрийн барилга байгууламжийг барьж, 2011 онд ашиглалтанд оруулсан. Уг замаар нүүрс тээврийн хүнд даацын тээврийн хэрэгслүүдээс гадна орон нутгийн зорчигч, тээврийн хэрэгслүүд чөлөөтэй зорчиж байна. 2012 онд Гаалийн Ерөнхий газраас уг замыг гаалийн замаар тогтоосон. Манай компани өөрийн эзэмшлийн уг авто замын арчлалт, засварын ажлыг орон нутгийн гэрээт компаниудаар гүйцэтгүүлдэг.





Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр

Төслийн үр өгөөжийг нэмэгдүүлж, нүүрсний чанарыг сайжруулах, улмаар тээвэрлэлтийн зардлыг бууруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор жилд 2.5 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий Нүүрс хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг барьж 2014 онд ашиглалтанд оруулсан.

Хуурай аргаар нүүрс баяжуулах энэхүү шинэлэг технологи нь таван төрлийн баяжуулах аргыг нэгтгэсэн баяжуулалтын цогц систем бөгөөд уурхайгаас олборлож буй бохирдол ихтэй нүүрсийг ус хэрэглэхгүй, хуурайгаар баяжуулж, нүүрсний үнслэгийг бууруулан хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чухал үүрэгтэй.

Нүүрс угаах үйлдвэр

Нүүрс угаах үйлдвэрийг БНХАУ-ын ШУӨЗО-ны Такашкен хотын аж үйлдвэрийн парсад (Монгол Улсын хилээс 15 км-ийн зайд) барьж байгуулан 2014 онд ашиглалтанд хүлээн авсан. Уг үйлдвэр нь жилд 3 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай бөгөөд хуурай аргаар баяжуулсан нүүрсийг цаашид нойтон аргаар угаан баяжуулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид хүргэх замаар төслийн үр өгөөжийг нэмэгдүүлж байна.

МЭС





Гаалийн хяналтын бүс

Хөшөөтийн уурхайг түшиглэн Гаалийн Ерөнхий газрын шийдвэрээр нийт 10 га газарт, 2018 онд Ховд аймгийн Үенч суманд 50 га газарт гаалийн хяналтын талбайг байгуулж, орчин үеийн мэдээллийн сүлжээг ашиглан иж бүрэн тоногосны дээр гаалийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрээр хийж байгаа нь гаалийн хяналт шалгалтыг шуурхай хэрэгжүүлэх таатай боломж бүрдүүлж байна. Мөн нүүрс угаах үйлдвэрийг түшиглэн 2020 онд гаалийн битүүмжилсэн агуулахыг ашиглалтад оруулсан.



Хөшөөтийн уурхайг түшиглэн орчин үеийн дэвшилтэт 80 орчим төхөөрөмжөөр тоноглогдсон, өндөр хүчин чадал бүхий нүүрс химийн лабораторийг 2013 оны гуравдугаар сараас ажиллуулж байна. Тус уурхайн түүхий нүүрс болон нүүрсний баяжмалын чанарын баталгааг олон улсын түвшинд найдвартай хангах зорилготой уг лабораторид нүүрсний дээжийг нунтаглан баяжуулж, техникийн шинжилгээ хийх замаар нүүрсний чанарын үзүүлэлтийг мэргэжлийн түвшинд тодорхойлж байна. Уг лабораторид 50 гаруй мэргэжилтэн ажилладаг бөгөөд өдөрт дунджаар 80 -140 орчим дээжийг шинжилж, нүүрсний коксжих чанарыг 11 үзүүлэлтээр тодорхойлж байна. Нүүрсний дээж бэлтгэл болон шинжилгээндээ ISO, MNS, GBT стандартуудыг ашигладаг. 2018 онд MNS ISO/IEC 17025:2007 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартаар итгэмжлэгдсэн.

Байгаль орчны хамгаалал


МоЭнКо ХХК нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эдгээрийн дотор газрын доорх гүний усны судалгааг хийж, 2008 оноос эхлэн гадаргын болон газрын доорх усны горимын мониторингийн цооногуудыг ажиллуулж байна. Хөшөөтийн уурхайн байгаль орчны суурь судалгаа, нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдлыг хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн уурхайн болон Хөшөөт гол орчмын бохирдсон хөрсийг цэвэршүүлэх, шимт хөрсний хадгалалт, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж буйн дээр байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах ажлыг урт болон дунд хугацааны төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлж, уг ажлын хүрээнд Дарви суманд 400 га, Цэцэг суманд 50 га талбайг хүнсний ногоо тарих зориулалтаар хашаалах, мод суулгац тарих, ургамал, амьтны судалгаа хийх, нөлөөллийн сумдад нөхөн сэргээлт хийх, хур хогийг цэвэрлэх, байгалийн цогцолборт газрыг хамгаалахтай холбоотой олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ирлээ.

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг багасгах гол хүчин зүйлийн нэг болох хатуу хучилттай авто зам барих асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэж, тоосжилт дарах зорилгоор уурхайд тогтмол усалгаа хийж байгаагийн дээр хуурай баяжуулалт хийгдэж буй орчинд тоосжилтоос хамгаалах тусгай зориулалтын хашаа барьж, мананжуулагч техникийг ашиглаж байна.



Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт



Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон Ажлын хэсэг жил бүр газар дээр нь танилцан дүгнэж, баталгаажуулж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2015 онд 80 хувь, 2016 онд 80.5 хувь, 2017 онд 84.1 хувь, 2018 онд 88 хувь, 2019 онд 95.4 хувь, 2020 онд 93.2, 2021 онд 90 хувиар дүгнэсэн байна. 2014-2021 онд байгаль орчныг хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажлын зардалд нийт 6.2 тэрбум төгрөг зарцуулж, дээрх хугацаанд 41400 ширхэг мод, суулгац тарьж, Ховд аймаг болон нөлөөллийн таван суманд хүлээлгэж өгсөн байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” тарих хөдөлгөөнд нэгдэж, Ховд аймгийн Алтай, Булган, Дарви, Цэцэг сумын нутаг дэвсгэрт 20 га талбайд ойн зурвас үүсгэхээр төлөвлөж, орон нутгийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.







Төслийн ажиллах хүч

Хөшөөт төслийн хэмжээнд 2200 хүн ажлын байраар хангагдан ажиллаж байна. Хөшөөтийн уурхайд ажиллаж буй МоЭнКо ХХК-ийн ажилтнуудын 87 хувь нь Ховд аймгийн иргэд байгаа бол гэрээт компаниудад ажиллагсдын 73 хувийг орон нутгийн иргэд бүрдүүлдэг. Компани орон нутгийн иргэдийг ажлын байран дээр нь мэргэшүүлэх сургалтыг тогтмол хийж, ажилтнуудынхаа ур чадварыг нэмэгдүүлж байна. Уурхайн бүсэд жилд дунджаар 30-40 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 5000 орчим хүнийг хамруулдаг бөгөөд мэргэшлийн зэрэг олгох, хүний нөөц, манлайлал, санхүү, хууль эрх зүй, байгаль орчин, мэдээлэл технологи, мэргэшсэн жолоочийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, онцгой байдал, анхан шатны тусламж үзүүлэх зэрэг олон төрлийн сургалтыг зохион байгуулж байна.



Төсвийн орлого бүрдүүлэлт

МоЭнКо ХХК нь 2014-2022 оны нэгдүгээр улиралд улс, орон нутгийн төсөвт нийт 148.5 тэрбум төгрөгийн татвар шимтгэлийн орлого оруулснаас 2017 онд 10.0 тэрбум, 2018 онд 21.9 тэрбум, 2019 онд 28.4 тэрбум, 2020 онд 15.1 тэрбум, 2021 онд 30.8 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Сүүлийн 5 жил дараалан шилдэг татвар төлөгч ТОП-100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарсан нь Хөшөөт төслийн нийт хамт олны нөр их хөдөлмөрийн үр дүн юм.

2014-2022.1 улиралд улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого
(тэрбум төгрөгөөр)

Аймаг, сумдын
төсөвт
төлсөн татвар

15.4

Хөшөөт
хөгжил сан

9.2

Улс, орон
нутгийн төсөв
148.5

Ашиг малтмал
ашигласны татвар

70

Агаарын бохирдлын
төлбөр


12.9




Бараа, ажил үйлчилгээ худалдан авалт

Төслийн хэрэгцээнд шаардлагатай бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авах замаар орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжиж 350 орчим орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна. Орон нутгаас нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ жил бүр тогтвортой өсөж, 2014 онд Ховд аймгаас 1.8 тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч байсан бол 2021 онд энэ тоо 125.6 тэрбум төгрөг болж өссөн байна.

2022 оны нэгдүгээр сараас эхлэн компанийн цахим хуудсаар дамжуулан ханган нийлүүлэгчдийг бүртгэж эхэлсэн ба катеринг, хөрс хуулалт, харуул хамгаалалт зэрэг туслан гүйцэтгэгчдийн орон нутгийн худалдан авалтын тайланг сар бүр авч нэгтгэн, цаашид орон нутгаас авах бараа материал, ажил үйлчилгээг нэмэгдүүлэх тал дээр санал зөвлөгөө өгч ажиллаж байна. Ховд аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс хүнсний бүтээгдэхүүн, барилгын материал, эмнэлгийн үзлэг оношилгоо, тээврийн хэрэгсэлийн болон эд хөрөнгийн түрээс, засвар үйлчилгээ, байгаль орчны, аюулгүй ажиллагаа, мэдээллийн технологийн үйлчилгээг худалдан авч байгаагийн дээр Ховд аймгийн Эко гутал ХХК, Михико ХХК, Эн Жи севен ХХК нь уурхайн ажилчдын бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын гутлыг уурхайн хэрэгцээнд бүрэн нийлүүлж байна.



Орон нутгийн ажил үйлчилгээ болон худалдан авалтын дүн, тэрбум төгрөгөөр (2018-2021 оны байдлаар)





Орон нутгийн хамтын ажиллагаа

МоЭнКо ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2014, 2017, 2021 онд Ховд аймагтай хамтран ажиллах гэрээ байгуулж, Ховд Хөшөөт Хөгжил санд гэрээний дагуу экспортолсон нүүрсний тонн тутмаас хөрөнгө оруулж, уг хөрөнгө оруулалтыг Ховд аймгийн ИТХ-аар жил бүр хэлэлцэн батлах замаар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбарт хэрэгжүүлэх олон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж байна. Өнгөрсөн хугацаанд нийт 370 төсөл хөтөлбөрийг Ховд Хөшөөт Хөгжил Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Манай компани 2014 оноос хойшхи хугацаанд Ховд Хөшөөт Хөгжил Санд нийт 9.2 тэрбум төгрөг төвлөрүүлснээс 2017 онд 665.7 сая, 2018 онд 1.6 тэрбум, 2019 онд 2.2 тэрбум, 2020 онд 1.5 тэрбум, 2021 онд 2.084 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бол 2022 оны эхний 3 сарын байдлаар 1.3 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлээд байна.

Орон нутгийн нүүрс ханган нийлүүлэлт

Хөшөөтийн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд тус компани Ховд аймгийн ард иргэдийн өмнө хүлээсэн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэд, байгууллагын хэрэглээний нүүрсийг нийлүүлдэг. Ховд аймгийн 16 сумын нүүрсний хэрэгцээг тус уурхайгаас хөнгөлөлттэй үнээр хангаж, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн үед аймгийн хэрэглэгчдэд, мөн Хөшөөт багийн ахмад настуудад жил бүр хэрэглээний нүүрсийг үнэ төлбөргүй олгодог.

2014-2021 онд Ховд аймгийн дулааны станц болон орон нутгийн иргэд, байгууллагын хэрэгцээнд 325 мянган тонн бүхэл болон эрчим хүчний нүүрс нийлүүлдэг байна. Мөн хугацаанд 9.5 мянган тонн нүүрсийг орон нутгийн байгууллага, иргэд, айл өрхөд хандивлажээ.



Хөшөөт багийн төвийн нүүлгэн шилжүүлэлт

2018-2019 онд нийгмийн хариуцлагын хүрээнд 215 өрх бүхий Ховд аймгийн Цэцэг сумын Хөшөөт багийн төвийг засаг захиргааных нь нэгжийн хувьд цогцоор нь нүүлгэн шилжүүлэх төслийг 10 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтээр амжилттай хэрэгжүүлж, жишиг багийн төвийг барьж байгууллаа.

Уг багийн төв нь захиргааны барилга, 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, соёлын төв, цахилгаан хангамж, уурын зуух, халуун усны газрын барилга, цэвэр бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, ус түгээх цэгүүд, амины орон сууцны барилгууд, өрх бүрт 900м² нэг загварын хашаа зэрэг 16 төрлийн дэд бүтцийн барилга байгууламжаас бүрдсэн. Мөн нийт айл өрхийн эд хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн компаниар хийлгэн нөхөн олговор олгосны дээр өрх бүрт 8 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж өгсөн.

Уг төслийн дараагийн шатны арга хэмжээ болох 70 гаруй өрхийн өвөлжөө хаваржааны үнэлгээг хийлгэж, нөхөн олговор олгох, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч эхлээд байна.



Хамтран ажиллаж буй гэрээт компаниуд

Бид Төслийг шилдэг технологи бүхий байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дэлхийд болон Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг сонгон хамтран ажиллаж ирлээ. Өнгөрсөн хугацаанд геологи хайгуул, уул уурхайн зөвлөх үйлчилгээг “Жон Т Бойд” компани (АНУ), олборлолтын ажлыг “Лейтон Азия” компани (Австрали), зураг төслийг ШУТИС, Уул Уурхайн хүрээлэн, “Шинь Ян” зураг төслийн хүрээлэн (БНХАУ), усны судалгааг “Акуа Терра” компаниар (Австрали) гүйцэтгүүлсэн.

2014 оноос хойш 100 хувь үндэсний аж ахуйн нэгжүүд уурхайн хөрс хуулалт, олборлолт, тээвэр, харуул хамгаалалт, катеринг, зам засвар, түлш ханган нийлүүлэлт, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, уулын ажлын үйлчилгээг Алтайн зам ХК, Моннис Майнинг ХХК, Мезом ХХК, түлш ханган нийлүүлэлтийг “Шунхлай трейдинг” ХХК, харуул хамгаалалтын үйлчилгээг Империа секьюрити ХХК, эмнэлгийн тусламж үйлчилгээг Эммед Партнер ХХК, хоол үйлдвэрлэл болон үйлчилгээг Монруд ХХК, нүүрс тээвэрлэлтийг Цаст Алтайн жинчид, Мөст цэвэрлэг булаг, Булган хөрс, Шонхорын хүлэг, Бадамлах Хөшөөт зэрэг Ховд аймгийн нийт 26 тээврийн компани 100 хувь гүйцэтгэж байна.





**Монгол Улс, Улаанбаатар-14250, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн
гудамж-23, Түшиг төв, 3-р давхар**